“Хургатай Хайрхан” ХХК MinePro Mongolia 2026-д оролцлоо



“Хургатай Хайрхан” ХХК MinePro Mongolia 2026 арга хэмжээний “Сорилт ба ирээдүй” сэдэвт хэлэлцүүлэгт оролцож, компанийн Гүйцэтгэх захирал Д.Ачит-Эрдэнэ “Овоот цогц төсөл: Байгальд ээлтэй, орон нутагт өгөөжтэй шийдлүүд” сэдвээр илтгэл тавилаа.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

Илтгэлийн гол санаа нь сорилтыг зөвхөн даван туулах саад бэрхшээл гэж харах бус, илүү хариуцлагатай, орон нутагт үр ашигтай, урт хугацааны үнэ цэнийг бий болгох боломж гэж харах, шийдэх тухай байв. “Овоот” төслийн жишээн дээр уул уурхайн төслүүдэд тулгардаг байгаль орчин, дэд бүтэц, орон нутгийн хөгжлийн сорилтуудыг зөв шийдэл, хамтын ажиллагааны үндсэн дээр орон нутаг болон улс орны бодит үр өгөөж болгон хувиргах боломжтойг онцоллоо.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

Илтгэлд байгаль орчны хариуцлагатай менежмент, агаарын чанарын тасралтгүй хяналт, усны үр ашигтай хэрэглээ, бүс нутгийн авто зам, тээврийн дэд бүтцийн хөгжил, байнгын ажлын байр бий болгох боломж, орон нутгийн худалдан авалт, бизнесийн боломжууд, мөн өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрүүдийг танилцууллаа.
Мөн төслийн хэрэгжилтийн явц, дэд бүтцийн хөгжүүлэлт болон төлөвлөж буй бондын санхүүжилтийн талаар мэдээлэл өгөв.



ХУРГАТАЙ ХАЙРХАН

Улсын хэмжээнд “Овоот” коксжих нүүрсний цогц төсөл нь экспорт, татварын орлогыг нэмэгдүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих,
Монгол Улсын хойд бүсийн дэд бүтцийг сайжруулах замаар улсын урт хугацааны хөгжилд хувь нэмэр оруулах зорилготой.

Сорилтоос — шийдэл рүү.
Шийдлээс — боломж руу.
Боломжоос — тогтвортой үр өгөөж рүү.



